








BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЪТ ХК

<p>Батлав.</p> <p> ТУЗ-ийн дарга Л.Ариунболд</p> <p></p>	<p>Боловсруулсан:</p> <p>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  О.Билгүүн</p> <p>Хянасан:</p> <p>ТУЗ-ийн хараат бус гишүүн  Ч.Зоригтбаатар</p> <p>Баталсан тогтоол: 2023.12.09</p>	
<p>Баримт бичгийн код: MBW-BOD-02</p>	<p>Хувилбар № 01</p>	<p>Шинэчилсэн: 2023/07/01</p>


ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

<p>Баримт бичгийн төлөв:</p> <p><input checked="" type="checkbox"/> Эх хувилбар</p> <p><input type="checkbox"/> Хуулбар</p> <p><input type="checkbox"/> Хүчингүй</p>	<p>Дардас</p>
--	---------------

	Эрсдийн удирдлагын бодлого	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-02	Шинэчилсэн: 2023/07/01

Баримт бичгийн шинэчлэгдсэн байдлыг бүртгэх хуудас

д/д	Хувилбар	Өөрчлөгдсөн огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан:
1.	Хувилбар . . .			
2.	Хувилбар . . .			
3.				
4.				
5.				
6.				
7.				
8.				
9.				
10.				
11.				
12.				
13.				

	Эрсдлийн удирдлагын бодлого	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-02	Шинэчилсэн: 2023/07/01

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү бодлогын зорилго нь “Монгол базальт” ХК-ийн стратегийн болон үйл ажиллагааны зорилго, зорилгоо биелүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах эрсдэлийн улмаас гарах алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах, түүнээс үр ашигтай гарах арга замыг тодорхойлох эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, удирдах, хэрэгжүүлэх, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. ЭРСДЭЛ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

2.1 Эрсдэл гэж компани зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохиролыг ойлгох ба компанийн бүхий л түвшинд үүсэх магадлалтай эрсдлүүдийг тодорхойлно.

2.2 Компанийн эрсдэлийн удирдлагын үйл явц нь эрсдэлийг тодорхойлж, бүртгэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах гэсэн үндсэн гурван үе шатанд хамаарна. Үүнд:

2.3 Эрсдлийг тодорхойлох, бүртгэх: Эрсдэлийг тодорхойлохдоо компанийн гадаад, дотоод нөхцөл байдал, орчны өөрчлөлт болон эрсдэлийн шинж чанар, эх үүсвэр, хүчин зүйлс, үр дагавар зэргийг харгалзан үзэх ба үйл ажиллагааны бүхий л чиглэлд эрсдэлийг тодорхойлж, бүртгэхийг зорино.

2.3.1 Эрсдлийг эх үүсвэрээс нь хамааран дараах ангилалаар тодорхойлж болно. Үүнд:

- Гадаад эрсдэл: Компанийн гадаад үйл явдал, хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй, компанийн зүгээс удирдах, хянахад хүндрэл, төвөгтэй эрсдэлүүд хамаарна.

- Дотоод эрсдэл: Компанийн дотоод үйл ажиллагаа, хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй компанийн зүгээс удирдах, хянахад хүндрэл багатай эрсдэлүүд хамаарна.

2.3.2 Эрсдлийг үр дагавараас нь хамааран дараах ангиллаар тодорхойлж болно. Үүнд:

- Стратегийн эрсдэл: Компанийн стратегийн зорилго, зорилт засаглалын тогтолцоонд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлийг ойлгоно.

- Санхүүгийн эрсдэл: Компанийн мөнгөн урсгал, гүйлгээний процесс, өглөг, авлагын хяналт, мөнгөн хөрөнгийн эх үүсвэр зэрэг санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлүүдийг ойлгоно.


- Үйл ажиллагааны эрсдэл: Компанийн дотоод үйл ажиллагаа, хүний нөөц, технологи, тоног төхөөрөмж, түүхий эдийн хомсдол зэрэг бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлүүдийг ойлгоно.

- Комплайнсийн эрсдэл: Компанийн дотоод дүрэм, журам, бодлогууд болон хууль тогтоомж, зохицуулалтын нийцэлд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлүүдийг ойлгоно.

- Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэл: Урт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, хүний эрхийн зөрчил үүсгэх эрсдэлүүдийг ойлгоно.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл: Ажилтнууд болон оролцогч талуудын эрүүл мэнд, амь насанд хохирол учруулж болохуйц эрсдэлүүдийг ойлгоно.

- Бусад эрсдэл: Дээр дурьдсанаас бусад бүх төрлийн эрсдэлийг хамааруулан ойлгоно.

	Эрсдлийн удирдлагын бодлого	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-02	Шинэчилсэн: 2023/07/01

2.4 Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч байж болох томоохон эрсдлүүдийг дараах байдлаар тодорхойлов.

2.4.1 Байгалийн давагдашгүй хүчин зүйл: Цаг агаарын нөхцөл байдал, үер, аадар бороо, гал түймэр, газар хөдлөлтийн нөхцөл байдлаас үйл ажиллагаа тасалдах эрсдэл

2.4.2 Цахилгаан хангамж: Үйлдвэрийн цахилгаан хангамжийн эх үүсвэр тасалдах нь үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл

2.4.3 Түлхүүр тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, саатал: Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн хэвийн тогтвортой ажиллагаа алдагдах эрсдэл

2.4.4 Түүхийн эдийн хангамж: Түүхий эдийн нөөцийн хомсдол үүсэх, кокс болон цавууны ханган нийлүүлэлт тасалдсанаас үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл

2.4.5 Вальютын ханшийн өөрчлөлт: Вальютын ханшийн огцом өсөлт үйлдвэрлэлийн өртөг зардалд нөлөөлөх эрсдэл

2.5 Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц томоохон эрсдлүүдээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаанд нөлөөлөх байдлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх дэд бүтэцийн хөгжүүлэлт хийх, түлхүүр тоног төхөөрөмжийг даатгуулах болон түүхий эдийн нөөцлөлт хийж, хангамжийн тасралтгүй систем хэрэгжүүлэх бодлого баримтлан ажиллана.

2.6 Эрсдэлийг үнэлэх: Эрсдлийн эх үүсвэр, үр дагаварыг нарийн шинжилж, ангилан ялгах, мөн эрсдлийг удирдан ажиллах дарааллыг сонгохын тулд ач холбогдол, үзүүлж болох сөрөг үр дагаврын түвшингээр зэрэглэж үнэлнэ. Компани дотооддоо баримтлах эрсдлийг үнэлэх арга аргачлалтай байх ба магадлалын шалгуур, үр дагаварын шалгуурыг ашиглана.

2.7 Эрсдлийг удирдах: Эрсдлийн үнэлгээний үр дүнд эрсдэлд үзүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох бөгөөд эрсдлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх улмаар мониторинг хийх замаар тасралтгүй сайжруулахыг эрмэлзэнэ.

Гурав. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ

3.1 Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.1.1 Соёлыг түгээх:

- Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн зүгээс эрсдэлийн удирдлагын хүчирхэг соёлыг бий болгоход манлайлан оролцох;


- Эрсдэлийн удирдлагын бодлого, заавар журмууд нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчлэх ба компанийн удирдлага, ажилтан бүр дагаж мөрдөх;

3.1.2 Үнэ цэнийг бүтээх: Эрсдэлийн удирдлага нь компанид үнэ цэнийг нэмэгдүүлэх компанийн бүхий л үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг байх;

3.1.3 Шийдвэр гаргалтанд ашиглагдах: Эрсдэлийн удирдлагыг шийдвэр гаргалтын түвшин бүрт ашиглагддаг байх;

3.1.4 Мэдээлэлтэй, ил тод байх:

- Эрсдэлийн удирдлага нь тодорхойгүй байдлыг ил болгох, системтэй, цаг хугацаандаа үнэн зөв мэдээлэл дээр суурилсан байх;

	Эрсдлийн удирдлагын бодлого	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-02	Шинэчилсэн: 2023/07/01

- Компанийн эрсдэлийн удирдлагын мэдээлэл солилцох ба зөвлөлдөх, хяналт ба мониторинг хийх үйл ажиллагаанд оролцох гадаад болон дотоод оролцогч талуудын оролцоо, хувь нэмрийг хүндэтгэн үздэг байх;

3.1.5 Тасралтгүй байх:

- Компанийн эрсдэлийн удирдлагын иж бүрэн тогтолцоог компанийн бүхий л түвшний үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжүүлж тасралтгүй сайжруулах;

- Компани нь стратеги зорилтууд, гадаад орчны өөрчлөлт, олон улсын практикт гарч байгаа эрсдэлийн удирдлагын шинэ мэдлэг, технологийг дотоод мэдээллийн систем, технологи, бодлого, заавар, журам зэрэг эрсдэлийн удирдлагын бүхий л элементүүдэд тусган байнга боловсронгуй болгон сайжруулж байх;

Дөрөв. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ

4.1 ТУЗ нь дараах байдлаар эрсдэлийг удирдана. Үүнд:

4.1.1 Компани нь эрсдэлийн удирдлагын бодлого боловсруулах ба ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороогоор дамжуулан компанийн үйл ажиллагааны бүхий л чиглэлийг эрсдэлийн удирдлагаар хангаж, дотооддоо мөрдөх эрсдэлийн удирдлагын бодлогыг баталж, түүнийг өөрчилнө;

4.1.2 Компанийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээ, түвшинг тодорхойлох;

4.1.3 Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батлах;

4.1.4 ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороогоор дамжуулан эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

4.2 Гүйцэтгэх захирал нь дараах байдлаар эрсдэлийг удирдана. Үүнд:

4.2.1 Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

4.2.2 Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулах;

4.2.3 Эрсдэлийн удирдлагын дотоод журам боловсруулж, батлах, хэрэгжилтийг хангах;

4.2.4 Компанид тулгарч байгаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн удирдаж байгаа талаар бүрэн гүйцэд мэдээллийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол хүргүүлэн, заавар, зөвлөмж авч ажиллах;

4.2.5 Гүйцэтгэх захирал нь компанийн дотоод зохион байгуулалтын нэгжийн удирдлагуудтай хамтран эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө нь компанид нийцтэй, үр дүнтэй эсэх, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

Тав. БУСАД

5.1 Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэгч ТУЗ, түүний дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, бусад хороод болон гүйцэтгэх захирлын санал, хөндлөнгийн аудитын тайлан, дүгнэлтэд үндэслэн Эрсдэлийн удирдлагын бодлогод өөрчлөлт оруулах саналыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.2 Эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж нийгэд мэдээлнэ.

--ооо--